



2026 оны 8 дугаар сарын 11-ний өдөр

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр хуульчилсан. Тус хуулиар олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих, ахмад настнуудын нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч, 10-аас доошгүй жил шимтгэл төлж өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэн, мөн Нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авч байгаа эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас хүрсэн ахмад настанд ажилласан жилээс нь хамааруулан суурь тэтгэврийг авах зохицуулалтыг тусгасан.

Геополитикийн тодорхой бус байдлаас шалтгаалан Монгол Улсын инфляцын цаашдын төлөв, цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага бий болж байна.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан зохицуулалтын хэрэгжилтийг наашлуулж, ахмад настанд олгох суурь тэтгэврийг 2026 оны 11 дүгээр сараас эхлэн олгож, ахмад настны орлогын баталгааг хангах шаардлага үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн орлого, зарлага болон чөлөөт үлдэгдлээс авах Засгийн газрын бондын хэмжээнд оруулах өөрчлөлтийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар ахмад настнуудын нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, олон давхаргат тэтгэврийн тогтолцооны эхлэлийг тавих үр дагавартай юм.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---